



“ АРИГ ГАЛ “
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 03 дугаар
сарын 11- ны өдөр

Дугаар 07/19

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай:

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь заалт Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээг хүргэх журам”-ын 2.2 –д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1.“Ариг гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 04-р сарын 26-ны өдрийн 17 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 15-р хороо, Үйлдвэрийн парк-1 хаягт байрлах компанийн байр. Хурлын танхимд хуралдуулсугай.

2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурьдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:

2.1 Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

2.2. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;

2.3. 2018 оны үйл ажиллагааны үр дүнгээр хуваарилах ногдол ашгийн хувь хэмжээг тогтоосон ТУЗ-ийн хурлын шийдвэрийг батлах.

2.4 АГ ХК-ийн ХЭХ-ын болон ТУЗ-ийн үйл ажиллагааны 2019 оны зардлын төсвийг хэлэлцэж батлах

3. Компанийн оршин байрлах хаягийн өөрчлөлтийг тусгаж шинэчилсэн компанийн дүрмийг хэлэлцэж батлах.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2018 оны 4 дүгээр сарын 02-ны өдрөөр тогтоосугай.

4. Хурал хуралдуулах тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо МХБ-д мэдэгдэх өдрийг 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд зарлах өдрийг 2018 оны 3 дугаар сарын 15 болон 4 дугаар сарын 01-ний өдрүүд байхаар тогтоосугай.

5.Энэ тогтоолын 4-т заасан эхний өдөр буюу 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөс Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах, мөн өдрөөс хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокерийн компанид хүргүүлэх, 2018 оны 3 дугаар сарын 15 болон 4 дүгээр сарын 01-ний өдрүүдэд өдөр тутам хэвлэгдэн гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх, радио, телевизээр мэдээлэх зэргээр хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

6. Дараах бичиг баримтуудыг компанийн байр болон хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер дилерийн компаниуд дээр бэлэн байлгаж, хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулсугай. Үүнд:

6.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолын хуулбар;

6.2. Хурлаар хэлэлцэх асуудлуудаар гарах шийдвэрийн үндэслэл болох үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;

6.3.Хурлын санал хураах хуудас.

6.4 ТУЗ-ийн энгийн болон хараат бус гишүүдийн тухай танилцуулга
6.5 ТУЗ-ийн болон ХЭХ-ын 2019 оны зардлын төсөв
6.6 Ххувьцаа эзэмшигчдэд 2018 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахаар шийдвэр гаргасан тухай ТУЗ-ийн 06/19 тоот тогтоолыг ХЭХ-аар хэлэлцүүлж дэмжүүлэх

6.7 Ариг гал ХК-ийн хаягийн өөрчлөлтийг тусгаж шинэчилсэн дүрмийн төсөл

7. Хурлын санал хураах хуудасны загварыг энэхүү шийдвэрийн Хавсралт №1-ээр баталсугай.

8. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 12 цагаар тогтоосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар ТУЗ-ийн гишүүн Д.Мөнхбатыг, хурлын тооллогын комиссын даргаар Д.Даваасүрэнг томилсугай.

10. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга материал, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисс /Д.Мөнхбат/-т даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

С.МӨНХЖАРГАЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН

Б.БОЛД

Б.АЮУШ

Б.ЁНДОНЖАМЦ

Э.БЯМБАЖАВ

Д.ГИВААПИЛ

С.АЛИМАА

Д.МӨНХБАТ